

28

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын  
2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн  
А/ДР...дугаар тушаалын хавсралт

**ТӨР, НИЙГМИЙН НЭРТ ЗҮТГЭЛТЭН, ҮНДСЭН ХУУЛИЙН ЭХИЙГ БАРИГЧ,  
ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН БАГШ, ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР,  
ПРОФЕССОР Б.ЧИМИДИЙН НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс жил бүр зохион явуулах Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Үндсэн хуулийг эхийг баригч, хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч Б.Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааныг (цаашид "уралдаан" гэх) зохион байгуулахад энэхүү журмыг баримтлана.
- 1.2. Уралдаан нь Үндсэн хуулийн эрх зүйн салбар дахь судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтнууд, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын багш, оюутны эрдэм шинжилгээний ажлыг урамшуулах, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлэх, хууль зүйн шинжлэх ухааны болон бодлогын тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой.
- 1.3. Энэхүү уралдааныг жил бүрийн 1 дүгээр сард Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж байна.

**Хоёр. Уралдааны зохион байгуулалт**

- 2.1. Уралдааныг зохион байгуулагч нь Хууль зүйн үндэсний хүрээлэн, Чимид сан, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль болон холбогдох бусад байгууллага байна.
- 2.2. Зохион байгуулагчид нь хөтөлбөр, зардлын тооцоог баталж байна.
- 2.3. Уралдааны санхүүжилтийг зохион байгуулах байгууллагууд гаргана.
- 2.4. Уралдааныг хоёр ангиллаар зохион байгуулна:
  - 2.4.1. Багш, судлаач, төрийн албан хаагч, хуульчдын хүрээнд;
  - 2.4.2. Оюутны хүрээнд.
- 2.5. Шүүгчдийн багийг ангилал тус бүрээр дараах таван бүрэлдэхүүнтэйгээр бүрдүүлж, Ерөнхий шүүгчийг шүүгчид дундаас жил бүр ээлжлэн сонгоно.
- 2.6. Багш, судлаач, төрийн албан хаагч, хуульчдын болон оюутны ангиллын шүүгчдийн бүрэлдэхүүнд:
  1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл;
  2. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн төлөөлөл;
  3. Хамтран зохион байгуулсан бусад байгууллагын төлөөлөл;
  4. Хууль зүйн доктор цолтой эрдэмтэн, багш нар байна.

**Гурав. Илтгэлийн уралдааны үе шат**

- 3.1. Нэгдүгээр үе шат: ирүүлсэн илтгэлээс ангилал тус бүрт 5 илтгэлийг дараагийн шатанд энэ журмын 6-д заасны дагуу шалгаруулна.
- 3.2. Хоёрдугаар үе шат: нэгдүгээр шатнаас шалгарсан ангилал тус бүрээс 5 (нийт 10) илтгэлийг нээлттэй хэлэлцүүлж энэ журмын 6 дугаар зүйлд заасны дагуу байр эзлүүлж шалгаруулна.
- 3.3. Илтгэлийн удирдамжийг (илтгэлд тавигдах шаардлага, хугацаа, хэмжээ зэрэг) илтгэлийг шалгаруулахаас 2 сарын өмнө, 10 дүгээр сарын эхний 10 хоногт багтаан уралдааны зарыг гаргаж байна.

29

3.4. Зохион байгуулагч нь илтгэлийг шалгаруулахаас 10 хоногийн өмнө илтгэлийг хүлээж авна. Уралдаанд ирүүлсэн илтгэлийг буцаан олгохгүй.

#### **Дөрөв. Шалгаруулалтад ирүүлэх илтгэлд тавигдах шаардлага**

- 4.1. Илтгэлийн хэмжээ 5-аас 8 нүүр хүртэл (хавсралтыг оролцуулан) нүүртэй байна.
- 4.2. Илтгэлийн мөр хоорондын зай 1.5, Arial mon 12-оор (MS Word) бичигдсэн байна. Цаасны хэмжээ А4, цаасны тал бүрээс 2,5 см хэмжээтэй байна.
- 4.3. Илтгэлийг цаасан болон файл хэлбэрээр өгнө.
- 4.4. Илтгэгч өөрийн товч намтар (CV)-ыг хавсаргана.
- 4.5. Илтгэлийг зохиогч нь нэг буюу хэд хэдэн этгээд байж болох ба зохиогчийн нэрийг шинэ мөрнөөс эхлэн баруун зах руу шахаж, налуу үсгээр бичнэ.
- 4.6. Илтгэл нь бүтэц, агуулгыг багтаасан товчлолтой байна.
- 4.7. Сэдэв нь зарласан сэдвийн хүрээнд багтсан байна.
- 4.8. Урьд өмнө нь хэвлэгдээгүй буюу илтгэлд тавьж хэлэлцүүлээгүй байна.
- 4.9. Зарласан хугацаанд багтаж илтгэлийг ирүүлсэн байна.

#### **Тав. Илтгэлийг хүлээж авах хугацаа**

- 5.1. Илтгэлийг уралдаан зарласнаас хойш тогтоосон хугацааны дотор хүлээн авна. Илтгэлээ Хууль зүйн үндэсний хүрээлэнд биеэр авчирч өгнө.

#### **Зургаа. Илтгэлийг шалгаруулах**

- 6.1. Уралдаанд оролцох бүтээлийг 2 үе шаттай шалгаруулна.
- 6.2. Тусгайлан байгуулагдсан шүүгчдийн баг Нэгдүгээр шатны шалгаруулалтыг уралдаан зарласнаас хойш 3.4-д заасан хугацаанд хүлээн авна.
- 6.3. Хоёрдугаар шатанд ангилал тус бүрээс 5 илтгэл шалгаруулах ба Эрдэм шинжилгээний илтгэлийг хэлэлцүүлэх хуралдаанаар эцсийн шалгаруулалт хийнэ.
- 6.4. Эцсийн шалгаруулалтыг жил бүрийн 1 дүгээр сарын эхний 10 хоногт багтаан хийнэ.
- 6.5. Цагийн зохион байгуулалт:
  - 6.5.1. Илтгэгч: Үндсэн илтгэл 15 мин
  - 6.5.2. Асуулт, хариултын цаг 10 мин

#### **Долоо. Шалгаруулалт, шагнал**

- 7.1. Шүүгчдийн комисст ерөнхий шүүгч болон ангилал тус бүрийн шүүгчид орно. Шүүгчдийн нэгдсэн дүнгээр илтгэлийг шалгаруулж дор дурдсанаар байр эзлүүлнэ.
- 7.2. Шагналын сан:
  - 7.2.1. Багш, судлаач, төрийн албан хаагч, хуульч
    - I байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
    - II байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
    - III байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
  - 7.2.2. Оюутан
    - I байр - Өргөмжлөл, зөврийн компьютер
    - II байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
    - III байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 7.2. Тусгай байрны шагналд энэ журмын 2.1-д заасан зохион байгуулагч байгууллагуудын ном бэлэглэнэ.
- 7.3. Шалгарсан илтгэлүүдээр эмхэтгэл гаргана.